



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 30 өдөр

Дугаар 482

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга
хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн “Хөвсгөл АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн 2016 он, 2017 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар нийт 88.6 сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. “Хөвсгөл АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. “Хөвсгөл АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Галбадрахад дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

2.1. Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлтийг ханган ажиллах;

2.2. Компанийн үйл ажиллагааны онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулан мөрдөж ажиллах, санхүүгийн программ хангамжийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн шинэчлэх, боловсронгуй болгох;

2.3. Тендерийн баримт бичгийг хууль, журмын дагуу боловсруулах, худалдан авах ажиллагаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөн ажиллах;

2.4. Компанийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй, 1985 онд ашиглалтад орсон, 17.3 сая төгрөгийн балансын үнэтэй, үлдэх өртөггүй, “Хөвсгөл зам” ХХК-ийн эзэмшил газар дээр байрлах, конторын барилгыг тус компанитай үүсгэсэн 42.9 сая төгрөгийн өр төлбөрийг хаах замаар данснаас хасах асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж шийдвэрлүүлэх;

2.5. Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б. ГАВАА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн
~~482~~ дугаар тогтоолын хавсралт

“Хөвсгөл АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанид хийсэн
шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг
арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах нэгж	Мөнгөн дүн /сая төгрөгөөр/	Зөрчил, дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны зөрчил	Захиргаа, удирдлагын хэлтэс	88.6	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хууль, холбогдох журмыг мөрдөж хэрэгжүүлэх
	Зөрчил, дутагдлын нийт дүн:		88.6	